

**МЭХГУУ-Н ҮЭ-ИЙН ХОЛБООНЫ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР
(2020-2030)**2020 оны 5 дугаар
сарын 20-ны өдөрУлаанбаатар
хот

Нэгдсэн үндэсний байгууллагаас Тогтвортой хөгжлийн зорилт 2030, МУ-ын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, МҮЭ-ийн холбооны Хөгжлийн хөтөлбөрт нийцүүлэн МЭХГУУ-н ҮЭ-ийн холбооны хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж батлах нь зүйтэй гэж IX Бага хурлын төлөөлөгчид санал нэгдлээ.

Индастриал глобал юнионы дараах 5 зорилт:

1. Ажилчдын эрхүүдийг хамгаалах
2. ҮЭ-ийг хүчирхэгжүүлэх
3. Дэлхийн хөрөнгөтнүүдтэй тулах
4. Эрсдэлтэй, аюултай ажлын байртай тэмцэх
5. Үйлдвэрлэлийн тогтвортой бодлогыг дэмжихэд зорилтоо чиглүүлнэ.

МЭХГУУ-н холбоо нь 2030 онд эрчим хүч, геологи, уул уурхайн салбарт хөдөлмөр эрхлэгчдийн 50-иас доошгүй хувийг эгнээндээ нэгтгэж, бүсчилсэн хэлбэрээр үйл ажиллагаа явуулан улсын хэмжээнд гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалан үйл ажиллагаа явуулна.

Эрхэмзорилго: Эрчим хүч, геологи, уул уурхайн салбарын ажилтнуудын хөдөлмөрлөх эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, хөдөлмөрийн нөхцөл, амьдралын түвшинг сайжруулна.

МҮЭ-ий холбооны хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг 4 жил тутам бага хурлаар гаргаж, жил бүр Гүйцэтгэх хорооны хурлаар шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг хэлэлцэнэ.

Хөгжлийн зорилт 1: Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбоог хүчирхэгжүүлэх

- 1.1 ҮЭ-ийн хороодын дарга нарыг чадавхижуулах сургалт зохион байгуулах, тэргүүн туршлага хуваалцах, гадаадад сургалтад хамруулах
- 1.2 МҮЭХ-ны хөгжлийн хөтөлбөрийн дагуу ҮЭ-ийн гишүүнчлэлээ жил бүр 5-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх, эвлэлдэн нэгдэх эрхийг сурталчлах
- 1.3 Эрхийн зөрчлийн эсрэг кампанит тэмцэл өрнүүлж, хууль зүйн зөвлөгөө, өмгөөллийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх
- 1.4 ҮЭ-ийн сонгуульт ажилтны эрхийн баталгааг хангах /нийгмийн хамгааллын бодлого/ хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх
- 1.5 ҮЭ-ийн хороодын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх

Хөгжлийн зорилт 2: Гадаадын хөрөнгө оруулалттай компаниудад эвлэлдэн нэгдэх эрхийн хэрэгжилтийг хангах

- 2.1 Гадаадын хөрөнгө оруулалттай /Үндэстэн дамнасан корпорациудын эсрэг ОУ-ын ҮЭ-ийн тэмцэлд нэгдэх/ компаниудын хүний эрхийн зөрчлийг эсрэг тэмцэл явуулах
- 2.2 Олон улсын хөдөлмөрийн байгууллагын суурь конвенциудын хэрэгжилтийн улсын үзлэг явуулах /МҮЭХ, ХЭҮК-той хамтрах/
- 2.3 Хөдөлмөрийн харилцаатай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах талаар тасралтгүй, үр дүнтэй арга хэмжээ авах
- 2.4 ОУ-ын ҮЭ-ийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран сэдэвчилсэн тэмцэл зохион байгуулах
- 2.5 Уурхайчдын цалин хөлс, нийгмийн хамгааллыг дэлхийн жишигт нийцүүлэх зорилгоор зорилтот үйл ажиллагаа явуулах

Хөгжлийн зорилт 3: Ажилтан хүний эвлэлдэн нэгдэх эрхийг хангах хүрээнд салбарын ҮЭ-ийн холбоонд нэгдүүлэх

- 3.1 Эвлэлдэн нэгдэх эрхийн эсрэг шийдвэр, арга хэмжээнүүдийн эсрэг тэмцэх хөтөлбөр боловсруулах
- 3.2 ҮЭ-үүдийн эрхийн тухай хууль болон МЭХГҮҮ-н ҮЭ-ийн холбооны дүрмийг шинэчлэн батлуулах
- 3.3 ҮЭ-д нэгдэх хүсэлтэй ажилтан бүр МЭХГҮҮ-н ҮЭ-ийн холбоонд элсэх, хамгаалуулах боломжийг бүрдүүлэх
- 3.4 МЭХГҮҮ-н ҮЭ-ийн холбооноос эвлэлдэн нэгдсэн гишүүддээ үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор бүсчилэн нэгжтэй болох
- 3.5 МЭХГҮҮ-н ҮЭ-ийн холбооны ажлын алба, нэгжийг зохион байгуулах

Хөгжлийн зорилт 4: Хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах

- 4.1 Хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээг хийлгэх кампанит аян өрнүүлэх
- 4.2 Эрсдэлтэй ажлын байрны жагсаалт боловсруулж даатгалд хамруулах хөдөлгөөн өрнүүлэх
- 4.3 Аваарь ослыг тэглэхийн тулд ХАБЭА-н удирдлагын тогтолцоог үр дүнтэй нэвтрүүлэхэд ҮЭ-ийн хяналтыг сайжруулах
- 4.4 МШӨ-ийг бууруулах зорилгоор эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэг, оношлогоог идэвхижүүлэх
- 4.5 ҮО, МШӨ-ний улмаас амь нас эрстсэн болон хүндээр бэртэж гэмтсэн тохиолдолд авах үйлчилгээг хүртээмжтэй, чанартай болгоход нөлөөлөх

Хөгжлийн зорилт 5: Тэгш хүртээмжтэй цалин орлого, баталгаатай ажлын байрыг дэмжих

- 5.1 Хөдөлмөрийн үнэлгээ, баялгийн тэгш хуваарилалтын тогтолцоог хамтын хэлэлцээрээр бүрдүүлэх
- 5.2 Бодит цалингийн худалдан авах чадварыг нэмэгдүүлэх
- 5.3 Ажлын байрны баталгааг хангах, эрсдэлтэй болон түр ажлын байрны эсрэг тэмцэх
- 5.4 Жендерийн мэдрэмжтэй төлөвлөлт, зорилтот бүлгүүд рүү чиглэсэн үйлчилгээ үзүүлэх
- 5.5 Зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

Сайн байна уу.

Ирүүлсэн бичиг баримтыг уншиж судлаад тэргүүлэгчдээрээ хэлэлцүүлэн “Хөгжлийн хөтөлбөр”-т дараах саналуудыг оруулах санал гарсаныг нэгтгээд явуулж байна:

А. Хөтөлбөрийг нэг маягийн загвараар боломжоор нь дэлгэрэнгүй хийсэн нь дээр юм болов уу

1. Өнөөгийн хөгжлийн зорилтуудын өнөөгийн нөхцөл байдал, товч дүгнэлт
2. Удирдлага зохион байгуулалт. Төв зөвлөл, салбар зөвлөлүүдийн оролцоо
3. Зорилтын шалгуур болон гүйцэтгэлийн үзүүлэлтүүд
4. Санхүүжилтийн, хөрөнгийн эх үүсвэр
5. Үйл ажиллагааны арай тодорхой үе шат, хугацаа

Б. Хөгжлийн зорилтуудын хүрээнд жишээ нь:

Хөгжлийн зорилт 1 . МЭХГУУҮЭХ хүчирхэгжүүлэх.

1.2 ҮЭХ-ийн хороодын гишүүнчлэлийг нэмэгдүүлэх- Монгол улсын хэмжээнд эрчим хүч, уул уурхайн хэдэн ААН байгууллагатай, хэд нь хувийн хэвшлийнх вэ. Тэр нь ҮЭХ-той эсэх гээд суурь судалгаа гаргах. Түүний үндсэн дээр тэр байгууллагууд руу чиглэсэн үйлдвэрчний эвлэлийн байгууллагын тухай сурталчилгаа хийнэ гэвэл зорилт нь тоо баримттай, гүйцэтгэлийн үе шатны тодорхой хугацаатай болох юм тэгээд суурь болгож авсан оноос хойш тийм тооны байгууллага дээр ҮЭ-ийн хороог байгуулсан гэсэн шалгуур үзүүлэлттэй болж болох юм.

1.3 Хууль зүйн яам зэрэг байгууллагаас хувь хүн эрхийн зөрчлийн талаар шүүх байгууллагад хандсан, шийдэгдсэн тоо баримтыг авч энэ баримт дээр тулгуурлан хууль зүйн зөвлөлгөө өмгөөллийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх асуудлаа хөндөх. Харьяа байгууллагууд дээр хуулийн зөвлөх нарыг ажиллуулах ажлыг үе шаттай хийнэ гэдэг ч юм уу. Мөн тэдэн байгууллагад ярилцлага хичээл орсон гээд шалгуур үзүүлэлтхийж болно

+ ҮЭ-ийн хорооны дарга нар, тэргүүлэгчдийг ижил төстэй дотоодын байгууллага дээр очиж туршлага судлах ажлыг зохион байгуулах

Хөгжлийн зорилт 2. Гадаадын хөрөнгө оруулалттай компаниудад эвлэлдэн нэгдэх эрхийн хэрэгжилт хангах

2.1 Хэдэн ийм компани байна. Яаж тэр компаниудад эвлэлдэн нэгдэх үзэл санаагаа хүргэх вэ гэх мэт. Мөн тодорхой тоо баримт, бүсчлэлээр явах нь зүйтэй болов уу. 2020 -2021 онд өмнөд бүс нутгаар гэх мэт

Хөгжлийн зорилт 4. Хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах

4.3 Энд салбарын байгууллагуудыг ХАБЭА-ийн олон улсын стандартуудад аажмаар шилжиж орох бодлогоо оруулж өгвөл зүгээр болов уу. Тухайлбал УБЦТС ТӨХК ОНSAS 18001-2012 стандартыг хэрэгжүүлж батламжаа авсан дараа нь ISO45001-2018 стандартад орно гэсэн төлөвлөгөөтэй байсан боловч мэргэжлийн биш удирдлага сургалтад хамруулаагүй байгаа. Хэрэв иймэрхүү олон улсын стандартыг нэвтрүүлж чадвал Хөдөлмөр хамгалаалал тал дээрээ удирдлагаас хамаарахгүй тогтолцоотой болох боломж бий болох байх.

Хөгжлийн зорилт 5. Ажлын байрны нөхцөл сайжруулах

5.3. Ажлын байрны баталгааг хангах, (улстөрийн болонашиг сонирхолын зөрчлөөр ажлын байр өөрчлөх, халах, м гэж нэмэх) түр болон эрсдэлтэй ажлын байрны эсрэг тэмцэх ;

+ хэрэгцээгүй орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн бус ажиллагсадыг мэргэжлийн хүний орон тоон дээр тавьж цалинжуулснаас үүссэн ажлын байрны ачааллын дарамтын эсрэг тэмцэх

+ байгууллагын мэргэжлийн удирдлагыг тогтвортой ажиллуулах тухайлбал нам солигдоход удирдлагад мэргэжлийн, туршлагатай, тухайн байгууллагад ажиллаж байсан хүний тоо 70%-с доошгүй байна гэсэн заалтыг тарифын хэлэлцээрт нэмж оруулах

5.4 + нэмж Захиргааны санаачилгаар ажилтнуудын ажлын байрыг дүүрэг хооронд сэлгэх, эмэгтэйчүүдийг хүүхдийн сургууль, цэцэрлэг, гэрээс хол ажлын байранд захиргааны санаачилгаар албадан шилжүүлэхийн эсрэг тэмцэх ,

+ Дикреттэй байгаа, хүүхдээ хараад гэртээ байгаа ээжүүдийг баялгийн, ашгийн, урамшууллын хуваарилалтаас хоцруулдаг байдлыг арилгах

+ Ажлын байрны тогтвор суурьшлын үзүүлэлтийг (хуучин хэрэглэж байсан) удирдлагын үйл ажиллагааг дүгнэхэд оруулдаг, харгалзаж үздэг болгох.

5.5 + Монголын бүтээмжийн төвтэй хамтран ажиллах. 5С чанарын, бүтээмжийн ажлуудыг харьяа үйлдвэр, байгууллагууд дээр сэргээх, шинээр эхлүүлэх

Саналыг нэгтгэсэн Ч.Өнөрцэцэг. УБЦТС ТӨХК ҮЭХ дарга

МҮЭ-ИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД

ЭРХЭМ ЗОРИЛГО

МҮЭ-ийн Холбооны эрхэм зорилго нь үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөнийг эрчимтэй хөгжүүлэх замаар гишүүд, иргэдийн хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг тууштай хамгаалж, тэдний амьдралын түвшинг байнга дээшлүүлэхэд оршино.

ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД

Хөгжлийн зорилт - 1:

Нийгмийн үйлчилгээг өргөтгөн сайжруулж, ажлын байрыг нэмэгдүүлж цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг хүн амын бодит хэрэгцээг хангахуйц түвшинд хүртэл өсгөх, худалдан авах чадварыг ямагт дээшлүүлж байхын төлөө тууштай тэмцэж гишүүд, хөдөлмөрчдийн нийгэм эдийн засгийн хөгжлийг хангах.

Хүрэх үр дүн:

- Нийгмийн даатгалын болон халамжийн үйлчилгээг өргөтгөн чанар, хүртээмжийг дээшлүүлүүлэхэд нөлөөлсөн байна.

- Үйлдвэрлэлийг хөгжүүлэн, ажлын байрыг нэмэгдүүлж, нийт ажилтнуудын цалинг амьжиргааг хангахуйц түвшинд хүртэл өсгөх замаар хүн амын амьдралын түвшинг дээшлүүлсэн байна.
- Өргөн хэрэглээний бараа үйлчилгээний үнэ, тарифын үндэслэлгүй өсөлтийг зогсоосон байна.
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг салбар бүрээр нэмэгдүүлэн тогтоож мөрдүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Ардчиллын үнэт зүйлсийг дэмжиж, Монгол улсад хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм байгуулж хөгжүүлэхэд хувь нэмэр оруулж, энх тайван байдлыг сахин хамгаалах үйл хэрэгт оролцох.
2. Боловсрол, эрүүл мэнд зэрэг хүн амд үзүүлэх нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж, мэдээллийг сайжруулах, хүнд суртал, шударга бус байдал гаргуулахгүй байхад нөлөөлөх
3. Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг амьдралын бодит хэрэгцээг хангахуйц түвшинд хүртэл нэмэгдүүлэхийн төлөө тууштай үйл ажиллагаа явуулах
4. Хүн амын нийгмийн хамгааллын тогтолцоог төгөлдөржүүлэх, нийгмийн даатгалын болон халамжийн сангаас иргэдэд олгож буй тэтгэвэр, тэтгэмж, тусламж, дэмжлэг, хөнгөлөлт, үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй болгон нэмэгдүүлэхэд идэвхтэй нөлөөлөх.
5. Эдийн засгийн өсөлтийг хангах, Засгийн газрын “ногоон эдийн засаг” хөтөлбөрийн хүрээнд албан болон албан бус хэвшилд байгаль орчин, уур амьсгалын сөрөг нөлөөгүй, зохистой хөдөлмөр хосолсон ногоон ажлын байрыг нэмэгдүүлэх хөгжлийн үндэсний загварыг нийгмийн түншлэгч талуудтай хамтран боловсруулж хэрэгжүүлэх
/Энэ чиглэлээр мэргэжил үйлдвэрлэлийн салбар, бүс нутгийн төлөөллийг хамруулсан ҮЭ-ийн сургалтын модуль боловсруулж сургагч багш нарыг бэлтгэх/
6. Нийгмийн түншлэлийн хоёр ба гурван талт харилцааг төгөлдөржүүлэн хөгжүүлж, Засгийн газар болон ажил олгогч эздийн улсын хэмжээний байгууллагатай үндэсний хэмжээнд хамтын хэлэлцээр байгуулж, хэрэгжилтийг нь хангуулах.
7. ҮЭ-ийн байгууллага бүрээр хамтын гэрээ, хэлэлцээр байгуулуулж, түүний тооцоо судалгаа, үндэслэл, үр нөлөөг сайжруулах.
8. Монгол улс дахь нийгмийн үйлчилгээг өргөтгөн сайжруулах болон цалин хөлсийг нэмэгдүүлэх боломж бололцооны талаар олон улсын ҮЭ-ийн байгууллагуудын экспертийг урьж судалгаа шинжилгээ хийлгэх.
9. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг салбар бүрээр нэмэгдүүлэн тогтоож мөрдүүлэх

10. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын "Цалин хөлсийг хамгаалах тухай" 95 дугаар конвенцид нэгдэн орох бэлтгэл хангуулах.
11. Алслагдсан хил хязгаар болон говийн бүсийн аймгуудад ажиллаж буй төсвийн байгууллагын ажилтнуудад бүсийн нэмэгдэл олгуулахын төлөө ажиллах.
12. Монгол ажилтны хийсэн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ олон улсын зах зээлийн жишигт хүрсэн үнээр борлогдож буй нөхцөлд тийм хэмжээний цалин хөлс авах хөдөлгөөн өрнүүлэх.
13. Үндэсний үйлдвэрлэлээ хөгжүүлж, жижиг, дунд үйлдвэрлэлийг бий болгох хөдөлгөөнийг дэмжиж мал аж ахуй, газар тариалангын бүтээгдэхүүнээр өөрсдийн хүнсний болон өргөн хэрэглээний хэрэгцээг бүрэн хангах,
14. Зохист хөдөлмөрийн үзэл санааг бүх чиглэлээр дэмжиж ажиллах
15. Өндөр ур чадвартай, залуу ажилтнаа гадаад оронд хямд хөлсөөр ажиллуулахгүй байх, гадаадад ажиллаж буй иргэдээ хамгаалах талаар дуу хоолойгоо гаргаж ОУХБ-ын конвенцийн дагуу ажиллах
16. Хямд өртөгтэй барилгын материал, байшин үйлдвэрлэх технологи нэвтрүүлэх ажлыг санаачлан иргэд хөдөлмөрчдийг хямд үнэтэй тохилог орон сууцаар хангах үйл ажиллагааг Засгийн газартай хамтран хэрэгжүүлэх.
17. Уул уурхайн ашигт малтмалыг түүхийгээр бус эцсийн бүтээгдэхүүн болгон гаргах, үйлдвэрлэлийг хөгжүүлэх ажлыг "Шинэ үйлдвэрлэл, Шинэ ажлын" байр уриан дор санаачлан нийгмийн түншүүдтэй хамтран ажиллах.

Хөгжлийн зорилт - 2:

Хөдөлмөрийн харилцааны хууль, тогтоомжийг ажиллагсдын эрх ашигт нийцүүлж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт шаардлагыг ажлын байр, үйлдвэрлэлийн орчин бүрт хангуулж, үйлдвэрлэлийн ослыг таслан зогсоох, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг бууруулахад идэвхтэй нөлөөлөх.

Хүрэх үр дүн:

- Монгол Улсын Үндсэнхуулинд заасан "Иргэдэрүүл, аюулгүй орчин дамыдрах, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрхтэй" гэсэн тунхаглал хэрэгжинэ.
- Хөдөлмөрийн харилцааны хууль, тогтоомж ажиллагчдын эрх ашигт илүүтэй нийцдэг болсон байна.
- Үйлдвэрлэлийн осл, мэргэжлээс шалтгаалах өвчлөлд нэрвэгдсэн хүмүүсийн тоо эрс буурсан байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, шаардлагыг ажлын байранд бүрэн хангуулж, үйлдвэрлэлийн осл, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг бууруулж, урьдчилан сэргийлэхэд нөлөөлөх.
2. Хөдөлмөр, нийгмийн харилцааны хууль тогтоомжийг боловсронгуй болгоход нөлөөлж, хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах.
3. Эхчүүдийн хамгааллын тухай ОУХБ-ын 183 дугаар конвенцид нэгдэн орох бэлтгэл хангуулах

4. Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэхэд ҮЭ-ийн оролцоог хангах
5. Албадан хөдөлмөр, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр болон хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхах явдлыг арилгахын төлөө ажиллах
6. ХАБЭА-н хяналтад ҮЭ-ийн оролцоог нэмэгдүүлж, байцаагчид ажиллуулах эрх зүйн орчин бүрдүүлэх.
7. Хөдөлмөрийн хуулийн зөрчлийн талаар мэдээлэх, ажил олгогчдын анхаарлыг төвлөрүүлэх, санал шаардлага тавих.
8. Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах асуудлаар хамтын гэрээ, хэлэлцээрт тусгаж хэрэгжүүлэх.
9. ХАБЭА-н талаар судалгаа шинжилгээ хийхийн зэрэгцээ ажлын байрны нөхцөлийн үнэлгээ, хэмжилт хийж дүгнэлт гаргаж байх лаборатори байгуулах,
10. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний талаар статистик мэдээг бодитой болгож, үйлдвэрлэлийн осол, гэмтлийг бүртгэх ажилд байнгын хяналт тавих.
11. Үйлдвэрлэлийн ослоор хүн нас барсан тохиолдолд тухайн байгууллагыг хаах хүртэл арга хэмжээ авахуулах.
12. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын тогтолцоог боловсронгуй болгоход нөлөөлөх.
13. МҮЭ-ийн гишүүдийн эрх зүйн хамгаалалын төвүүдийг бэхжүүлсний үндсэн дээр “Нэг цэгийн үйлчилгээ”-г нэвтрүүлж гишүүд хөдөлмөрчдийн санал хүсэлт хүлээн авах, барагдуулах ажлыг шуурхай болгож, тэдэнд хууль эрх зүйн зөвлөгөө үнэ төлбөргүй өгч, хөнгөлөлттэй нөхцлөөр өмгөөллийн туслалцаа үзүүлж байх

Хөгжлийн зорилт - 3:

Хөдөлмөрчдийн МҮЭ-д эвлэлдэн нэгдэх эрхийг хангуулж, түүний оновчтой бүтэц, зохион байгуулалтыг бүрдүүлж ажиллах

Хүрэх үр дүн:

- Хөдөлмөрчдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хангуулсан байна.
- ҮЭ-ийн байгууллагын оновчтой бүтэц, зохион байгуулалтыг бүрдүүлсэн байна.
- ҮЭ-д гишүүн элсүүлэх, хороо байгуулах замаар гишүүдийн тоог нэмэгдүүлсэн байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Албан бус эдийн засагт ажиллагчдын үйлдвэрчний эвлэлд эвлэлдэн нэгдэх эрхийг хангуулж гишүүнчлэлийн тоог нэмэгдүүлэх.
2. Үйлдвэрчний эвлэлийн эв нэгдлийг бэхжүүлж, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгож хөгжүүлэх.
3. Үйлдвэрчний эвлэлийн гишүүнд залуучууд, эмэгтэйчүүдийг өргөнөөр элсүүлж, тэдний идэвхтэй оролцоог хангах.

4. Иргэд, хөдөлмөрчид, гишүүдийн хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах талаар үйлдвэрчний эвлэлийн тэмцлийг зохион байгуулах.
5. Эвлэлдэн нэгдэх эрхийн тухай олон улсын гэрээ, конвенц, үндэсний хууль тогтоомж, хөдөлмөрчид эрх ашгаа хамтран хамгаалахын давуу талыг харуулсан сурталчилгааны материал олноор бэлтгэх, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр өргөн сурталчлах.
6. Гишүүн ҮЭ-ийн холбоодтойгоо хамтран ҮЭ-гүй байгууллагуудын судалгаа гаргаж, МҮЭ-ийн гишүүн байхын давуу талыг ойлгуулж, гишүүнчлэл нэмэгдүүлэх компанит ажил жил бүр зохиож, ҮЭ-ийн хороодыг шинээр системтэйгээр байгуулах
7. Гишүүн ҮЭ-ийн холбоодынхоо ажлыг дүгнэж оны шилдгүүдийг шалгаруулж тэргүүний арга барилыг нь бусдад түгээж байхын зэрэгцээ ҮЭ-д ээлтэй ажил олгогч, шийдвэр гаргагч, байгууллага хүмүүсийг тодруулан урамшуулж байх.
1. 8. Бүтцийн өөрчлөлт, хувьчлал хийгдэж буй байгууллагуудад ҮЭ-ийн үйл ажиллагааг тогтвортой үргэлжүүлэх, шинээр зохион байгуулагдаж буй байгууллагуудад ҮЭ-ийг зохион байгуулах ажлыг цаг алдалгүй хийж байх.
8. Эвлэлдэн нэгдэх эрхийг хангахтай холбогдсон хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгож “Үйлдвэрчний эвлэлийн эрхийн тухай” хуулийн эрх хэмжээг нэмэгдүүлэх санал боловсруулж тавих
9. Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ҮЭ-ийн тухай ойлголт өгөх хичээлийг мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, их дээд сургуулиудын хичээлийн хөтөлбөрт оруулах
10. МҮЭ-ийн Холбооны дотоод мэдээллийн сүлжээг өргөжүүлэн багтаамж, чадал, хурд, хамгаалалтыг нэмэгдүүлэх
11. МҮЭ-ийн Холбооны гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлж олон улсын төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах

Хөгжлийн зорилт - 4:

МҮЭ-д хүний нөөцийн удирдлага /менежмент/-ыг хэрэгжүүлж, ажиллагчдын эрх ашгийн төлөө тэмцэж чадах, ёс зүйтэй, мэргэшсэн боловсон хүчинтэй болох, тэдгээрийг чадавхжуулж, тогтвор суурьшилтай ажиллуулах.

Хүрэх үр дүн:

- МҮЭ-ийн ажилтнуудын нөөц бүрдэж, байгууллагадаа үнэнч, өөрсдийн ажилдаа дур сонирхолтой, өндөр түвшний мэдлэг ур чадвартай болж, байгууллагынхаа зорилго, хөгжлийн төлөө нэгдмэл үзэл бодолтой ажилладаг болсон байна.
- МҮЭ-ийн ажилтны нэр хүндийг дээшлүүлэх замаар шат шатны иргэдийн хуралд төлөөлөлтэй болно.
- ҮЭ-ийн байгууллагын соёл дээшилж, нэр хүнд, шинэ имиж бүрдсэн байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Эмэгтэйчүүд, залуучуудын оролцоог харгалзан хүний нөөцийг төлөвлөх, бүрдүүлэх, сонгон шалгаруулах журам гаргаж хэрэгжүүлэх
2. ҮЭ-ийн бүх түвшний ажлын албаны ажлын байранд шинжилгээ хийж, ажлын байрны тодорхойлолтыг жил бүр авч үзэж оновчтой болгож байх.
3. Багш арга зүйчид болон сургалтад хамрагдсан хүмүүсийг ҮЭ-ийн хамтын үйл ажиллагаанд татан оролцуулах замаар практик ажилд сургах

4. Нийгэм, эдийн засаг болон хөдөлмөрийн харилцааны асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийлгэх замаар ажилтнуудыг мэргэшүүлэх.
5. ОУҮЭ-ийн холбооны Ази номхон далайн бүсээс ҮЭ-ийн “Leadership” бэлтгэдэг дээд курст залуу ажилтан, сонгуультнаас явуулж байх
6. Сургалтын агуулгыг сайжруулан чанарыг дээшлүүлж, ҮЭ-ийн идэвхтэн, сонгуультан, ажилтан, хороодын дарга нарын сургалтын хэрэгцээг нарийвчлан тодорхойлж, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.
7. МҮЭ-ийн ажилтан, сонгуультан түүний дотор залуу ажилтан, иргэд хөдөлмөрчдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор гадаад оронд сургаж бэлтгэх ажлыг өргөжүүлж, үр өгөөжийг тооцох
8. МҮЭ-ийн Холбооны дэргэд Сургалтын иж бүрэн цогцолбор байгуулж, сургалт арга зүйн төв болон бүсийн сургалтын төвүүдийн материаллаг баазыг бэхжүүлж, нэгдсэн хөтөлбөрийн дагуу үйлдвэрчний эвлэлийн гишүүд, идэвхтэн сонгуультан, ажилтнуудын мэдлэг, боловсролыг дээшлүүлж, давтан сургаж байх
9. Хөдөлмөрийн дээд сургуулиар дамжуулан хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах нөхцөл бүрдүүлэх
10. ҮЭ-ийн ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэхийн тулд ҮЭ-ийн бүх түвшний байгууллагын дэргэд нийгмийн халамжийн сан бий болгож ажиллуулах.
11. Сонгуультнуудыг урамшуулах болзол, механизм бий болгох, боловсон хүчнийг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах боломжийг бүрдүүлэх.

Хөгжлийн зорилт - 5:

МҮЭ-ийн Холбооныхоо зорилго, зорилтууд, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн нөөцийг бүрэн бүрдүүлж, улмаар харъяа газар, аж ахуйгаа бэхжүүлэх, орлогоо нэмэгдүүлэх замаар санхүүгийн хүчин чадлаа дээшлүүлж, гишүүдэд үзүүлэх үйлчилгээг өргөжүүлэх

Хүрэх үр дүн:

- ҮЭ-ийн бүх шатанд санхүүгийн удирдлага, хяналтын тогтолцоог нэвтрүүлж, ил тод байдлыг хангасан байна.
- ҮЭ-ийн гишүүдийн татварын зарцуулалтыг ил тод болгож, ҮЭ-ийн хороо, холбоод эв санааны нэгдлийн сантай болж, хуримтлалын сангаа арвижуулсан байна.
- МҮЭ-ийн Холбооны харъяа газруудын менежментийг боловсронгуй болгох, хөрөнгө оруулах замаар түүний орлогыг нэмэгдүүлж, гишүүдэд үзүүлэх үйлчилгээг өргөтгөсөн байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Үйлдвэрчний эвлэлийн өмч хөрөнгө, санхүүгийн бие даасан байдлаа бэхжүүлэх.
2. Үйлдвэрчний эвлэлийн гишүүд болон ажилтан, сонгуультанд үнэ төлбөргүй буюу хөнгөлөлттэй үнээр үзүүлж буй үйлчилгээг өргөжүүлж, тэдний эрэлт, хэрэгцээнд тулгуурлан үйлчилгээний шинэ хэлбэрүүдийг бий болгох.
3. Өнөөгийн байгаа материаллаг бааздаа тулгуурлан аялал жуулчлал, соёл урлаг, нийтийн биеийн тамир хөгжүүлэх

4. ҮЭ-ийн харъяа газруудын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгож үр ашгийг дээшлүүлэх
5. Орлого, зарлагын зохистой харьцааг бий болгож, ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг гадны бусад байгууллагуудын жишигт хүргэх
6. Төсөв, түүний хуваарилалтыг боловсронгуй болгох.
7. Бараа материал худалдан авах, барилгын засвар хийлгэх зэрэг ажил үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх журмыг боловсронгуй болгох.
8. ҮЭ-ийн гишүүд, гишүүн байгууллагын татвар төлөлт, хураалтыг жигдрүүлэн сайжруулж, татварын орлогын эх үүсвэр, эзлэх хувийг нэмэгдүүлэх.
9. ҮЭ-ийн шат шатны байгууллагыг төсөвтэй болгож, гишүүдийн татварын орлогоос цалин хөлсөнд зарцуулах зохистой хэмжээг тогтоох, үйл ажиллагаанд зарцуулж буй хувийг нэмэгдүүлэх.
10. Санхүүгийн удирдлагын тогтолцоог шинэчилж, санхүү бүртгэл, тайлан тооцооны олон улсын стандартыг мөрдөх
11. МҮЭ-д хэрэгжиж байгаа гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрт тавих санхүүгийн хяналтыг сайжруулж, үр өгөөжийг нэмэгдүүлэх
12. Аймаг, нийслэлийн ҮЭ-ийн байгууллагын үл хөдлөх хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх
13. Санхүүгийн зах зээл дээр үйл ажиллагаа явуулах.

---oOo---